



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 653

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 95,000,000.00 (ерэн таван сая) төгрөгийн балансын анхны үнэ, 95,000,000.00 (ерэн таван сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1(нэг) ширхэг автомашиныг "Дорноговь АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг, "Дорноговь АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
65.3. дугаар албан тогтоолын хавсралт

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨТЭЙ БҮРТГЭЛТЭЙ

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Тоёота Ландкрузер-200 2232 УНЗ арал JTMDEV09J7B4056009	2014	10200	95,000,000.00	9,500,000.00	0.00	"Дорноговь- Азза" ТӨХК
	НИЙТ ДҮН			95,000,000.00 /Ерэн таван/			